



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А107

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/104 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй зочлох үйлчилгээний байгууллагууд, зоогийн газрын тогооч, менежерийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Монголын ресторан зоогийн газруудын холбоо” ГҮТББ-аас зохион байгуулж байгаа сургалтад дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэх төсвийг хавсралтаар баталж шаардагдах зардал 243.600.000 (хоёр зуун дөчин гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган, “Монголын ресторан зоогийн газруудын холбоо” ГҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-г үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аядал жуулчлалтын газрын
даргын 2024 оны 03 сарын 07 өдрийн
108 дугаар тушаалын хавсралт



“МОНГОЛЫН РЕСТОРАН ЗООГИЙН ГАЗРУУДЫН ХОЛБОО” ГҮТББ-ААС
ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГАА СУРГАЛТАД ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Сургалтын сэдэв	Улс	Хугацаа	Хүний тоо	Нийт зардал
1	Турк, Араб хоол	Турк (Стамбул хот)	2024 оны 3 сард	6	24,990,000
2	Кавказ хоол	Гүрж (Тбилис)	2024 оны 3 сард	6	27,090,000
3	Mediterranean (дундад тэнгис) Европ хоол	Серби улс (Белград)	2024 оны 3 сард	6	31,290,000
4	Ази хоол	Гонконг	2024 оны 3 сард	8	33,440,000
5	Дундат Ази хоол	Узбекистан (Ташкени)	2024 оны 3 сард	6	24,990,000
6	Тайланд хоол	Тайланд (Пукет)	2024 оны 2-3 сард	8	28,000,000
7	Япон хоол	Япон (Токио)	2024 оны 3 сард	6	36,000,000
8	Орос, Европ хоол	ОХУ (Эрхүү, Красноярск)	2024 оны 3 сард	10	37,800,000
Нийт					243,600,000